

# Шагай

Хоёр жаал тэнцүү тооны шагай хуваан аваад тэмээ, морь, хонь, ямааны тоонууд хоорондоо ижил байхаар хоёр цуваанд өрж тоглож байв.

Өрсөн хоёр шагайн цуваан дах малын дэс дараалал нь өөр байв.

Аль нэг цувааны хоёр малыг хооронд солих замаар хоёр цувааг ижил дараалалтай болгохоор шийдэв. Тэдэнд тусална уу.

## Оролт:

Шагайны 4 бэрхийг ялгаатай үсгээр А, С, В, D гэж тэмдэглэвэл эдгээр үсгээс бүтсэн 2 тэмдэгт ( $10^6$ -с хэтрэхгүй урттай) мөр нэг нэг мөрөнд өгөгдөнө.

## Гаралт:

Хамгийн цөөн солилтын тоог илэрхийлсэн нэг бүхэл тоо байна.

## Жишээ 1

### Оролт

ABCDC

CDCBA

### Гаралт

2

## Жишээ 2

### Оролт

BDACACDBDA

DABBCDADAC

### Гаралт

7